



Эдийн засгийн өсөлтийн хурд саарчээ

Энэ оны I улирлын байдлаар ДНБ (2005 оны зэрэгцүүлэх үнээр) өнгөрсөн оны мөн үеэс 7.2% өссөн байна. Энэ нь 2010 оны IV улирлаас хойш хамгийн сул үзүүлэлт бөгөөд өнгөрсөн оны мөн үед ДНБ 14.6% өсөж байв. Эдийн засгийн өсөлтийн хурд ийнхүү саарахад нүүрсний үнийн уналт болон БНХАУ-ын эрэлт буурч байгаа нь нөлөөлжээ. ДНБ оны үнээр 2,894 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 16.3% өссөн байна.




Улсын нэгдсэн төсвийн алдагдал 133 тэрбум төгрөг

2013 оны эхний хагас жилд Улсын нэгдсэн төсвийн орлого өссөн дүнгээр 2,505, зарлага 2,638 тэрбум төгрөг болж, төсвийн тэнцэл 133 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад орлого 6.4% өсөж, зардал 10% буурчээ. Харин Улсын төсвийн орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17.5%, зарлага 7.1% өсч улмаар алдагдал 23% буурсан боловч Улсын төсөв өссөн дүнгээр 393 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.



Гадаад худалдааны алдагдал 1 тэрбум ам.доллар

2013 оны эхний 6 сарын байдлаар нийт барааны эргэлт өмнөх оны мөн үеэс 8.6% буурч 5,094 сая ам.доллар болжээ. Экспорт 10.5%, импорт 7.3% буурснаас гадаад худалдааны алдагдал 1,047 сая ам.долларт хүрэв. Харин өмнөх сарынхтай харьцуулбал экспорт 11.7%, импорт 17.1% буурсан байна. Гэвч импортын хэмжээ экспортынхоос 1.6 дахин их хэвээр байна. Экспортолсон чулуун нүүрсний үнийн дүн эхний 6 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 50%, биет хэмжээгээр 26.3% буурчээ.




Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тогтвортой байна

Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш 6 дугаар сард харьцангуй тогтвортой, 1,437.78 байв. Энэ нь өмнөх сарынхтай харьцуулахад өөрчлөгдөөгүй боловч өнгөрсөн оны мөн үеэс 8.3% суларсан үзүүлэлт юм. Гадаад валютын нийт албан нөөц 3106.3 сая ам.доллар болсон нь өнгөрсөн сарынхаас 8.3%, оны эхнээс 17.8% буурч, өмнөх оны мөн үеэс 6.8% өссөн үзүүлэлт боллоо.



Хэрэглээний үнийн улсын индекс 6 дугаар сард мөн л буурч, 8.8% болжээ. Энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 5.9 нэгжээр бага үзүүлэлт юм. Инфляц оны эхнээс 4.7% өссөн бол өмнөх сарынхаас 0.3% буурсан байна.

Ерөнхий индекс өмнөх сарынхаас буурахад хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнийн дүн 0.9%, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 0.7%, тээврийнх 0.9% буурсан нь голлон нөлөөлжээ. Гэвч өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны үнэ 11.3%, орон сууцны түрээсийн үнэ 5.3%, хувцас, бөс бараа, гуталны үнэ 12%, согтууруулах ундаа, тамхины үнэ 51% өссөн байна.




Эх сурвалж: УСХ, МБ

САНХҮҮГИЙН САЛБАР: МӨНГӨ, ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛ


Мөнгөний нийлүүлэлт (M2) 8 их наяд төгрөг

M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 13.5% нэмэгдэж, өнгөрсөн сарынхаас 1.2% өсөж 8 их наяд төгрөг (5.6 тэрбум ам.доллар) болжээ. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө өнгөрсөн оныхоос 6.2% буурч, өмнөх сарынхаас 0.6% өсөж 835 тэрбум төгрөг болсон нь нийт мөнгөний 10.4%-ийг эзэлж байна. 2010 оны 4 дүгээр сард 14.1% байсан энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд буурсаар байгаа юм.




Валютын хадгаламж буурсаар

Нийт хадгаламжийн хэмжээ өмнөх онтой харьцуулахад 15.4% өсөж, өмнөх сарынхаас 1.9% буурч 5 их наяд төгрөг (3.5 тэрбум ам.доллар) боллоо. Үүнээс төгрөгийн хадгаламж 3.9 их наяд бол валютын хадгаламж 1.1 их наяд төгрөг байна. Төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үеэс 27.9% өсөж, валютынх 14.5% буурсан бол өмнөх сарынхтай харьцуулахад төгрөгийн хадгаламж 0.2%, валютынх 7.5% буурчээ.



Чанаргүй зээлийн хэмжээ 0.4% буурав

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх сарынхаас 4.6%, өнгөрсөн оны мөн үеэс 36.2% тус тус нэмэгдэж, 8,608 тэрбум төгрөг (5.9 тэрбум ам.доллар) боллоо. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх сарынхаас 0.4% буурч, өнгөрсөн оныхоос 2.8% өссөн бөгөөд нийт зээлийн 3.7%-ийг эзэлж байна.



Эх сурвалж: УСХ, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж Ерөнхийлөгчөөр улиран сонгогдлоо.
- > Монголбанк бодлогын хүүг 1.0 нэгж хувиар бууруулан 10.5 хувь болгов.
- > Хөдөө аж ахуйн биржээр анх удаа хонины ноос арилжаалж эхэлжээ.
- > Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт байрлах "Салхит Уул" салхин станц ашиглалтад орлоо. 50 мВт-ын суурилагдсан хүчин чадалтай бөгөөд 100 мянган өрхийг эрчим хүчээр хангах энэхүү цахилгаан станцыг "Клин Энержи" компани 175 орчим тэрбум төгрөгөөр бүтээн босгожээ.
- > Засгийн газар, Монголбанкнаас эхлүүлсэн орон сууцны ипотекийн зээлийн дэд хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкууд 6 дугаар сарын 17-ноос эхлэн 8+/-1% хүүтэй орон сууцны зээл олгож эхлэв.

Хураангуй

Он гарсаар шинээр олгосон ипотекийн зээлийн хэмжээ тасралтгүй өсөж ирсэн. Энэ оны эхний таван сарын байдлаар ипотекийн зээлийн үлдэгдэл болох 1 их наяд төгрөгийг нийт 32000 гаруй зээлдэгчид арилжааны банкууд голчлон өөрийн эх үүсвэрээс олгосон байдаг. Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 17.5% бөгөөд жигнэсэн дундаж хугацаа нь 13 жил байв. Харин 6 дугаар сараас 8+/-1% хүүтэй ипотекийн зээлийн хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс эхний 19 хоногийн байдлаар шинээр зээл олгохын зэрэгцээ өмнөх зээлдэгчдийн 40%-ийн зээлийн хүүг шилжүүлсэн байна. Монгол Улсад хөрөнгийн болон таваарын зах зээлд хөрөнгө оруулах нөхцөл тааруу байгаагаас хүмүүс үл хөдлөх хөрөнгөд мөнгөө байршуулдаг. Өөрөөр хэлбэл, санхүүгийн зах зээлийн сул хөгжил нь үл хөдлөх хөрөнгийн зах зээл тэлэхэд хүргэж байна. Хүн ам тогтмол өсөж, иргэдийн худалдан авах чадвар харьцангуй сайжирч, эрэлт нэмэгдэж байгаагийн зэрэгцээ үл хөдлөх хөрөнгийн салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ тэлж байгаа нь цаашдаа орон сууцны үнийг өсгөх магадлал өндөр.

Иргэд орон сууцаа аль болох бага зардлаар авах эрмэлзлэлтэй байгаа. Гэвч энэхүү хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр хүрэлцээтэй эсэх, ирээдүйд ипотекийн зээлийн хүү бага байж чадах эсэх нь тодорхойгүй хэвээр. Нөгөө талаас банк, даатгалын компаниуд ч ипотекийн хөнгөлөлттэй зээлийг цаашид олгох сонирхолтой байна. Энэ салбарт өөрсдийн мөнгийг оруулж эргэлдүүлэх нь тэдний хувьд ч эрсдэл багатай хөрөнгө оруулалт юм.

Монголбанк бодлогын хүүгээ тогтмол бууруулж байгаа нь эхний ээлжинд богино хугацааны хүүгийн түвшинд л нөлөөлөх төлөвтэй. Харин урт хугацааны зээлийн хүүгийн түвшинд Засгийн газрын өрийн бичиг мэтийн санхүүгийн урт хугацааны хэрэгслүүд л голлон нөлөөлнө. Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх нь найдвартай тооцогдож, инфляцийн аюул байхгүй болох цагт л ипотекийн зээлийн хүү зах зээлийн жамаар бага байх болно. Өөрөөр хэлбэл, Монголын үнэт цаас, өрийн бичгүүдийг худалдан авах сонирхол их байх тусам хүү багатай зээлийн эх үүсвэр бүрдэх боломжтой. Мөн урт хугацаанд инфляцийн түвшин бага байвал жирийн иргэдийн орон сууц худалдан авах чадвар сайжирна. Харин хөрөнгө оруулагчид илүүдэл хөрөнгөө нэмүү өртөг шингээсэн үйлдвэрлэлийн салбарт байршуулахыг чухалчилдаг болсон цагт орон сууцны эрэлт хэрэгцээ болон үнэ өсөхөд нөлөөлөхгүй. Үүний тулд үл хөдлөх хөрөнгийн салбарт оруулж буй хөрөнгийн өгөөж бага байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, байр түрээслүүлэх үнийн өсөлт байр худалдан авах үнийн өсөлтөөс бага байх хэрэгтэй юм.